



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим худас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
ҮНЭН БА ЗӨВ НАМД

2024.08.04 № 1НАГ-2024/ЗЧИТАА-90
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Үнэн ба зөв намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-

2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Үнэн ба зөв намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Үнэн ба зөв намын мөрийн хөтөлбөр / хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА





ҮНЭН БА ЗӨВ НАМ

ХҮЧТЭЙ СӨРӨГ ХҮЧИН

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр

АЙМАГ, ОРОН НУТГАА ЗАСАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Сэлэнгийн ард иргэд бид:


- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
 - Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
 - Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийн эрхэм зорилго болгоно гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн зорилго дор сайн чигийг зөв заах ҮНЭН БА ЗӨВ НАМ-ын мөрийн хөтөлбөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ

- 1.1 Монгол судлалыг хөгжүүлэхийг дэмжиж, дотоод, гадаадын судлаач, эрдэмтдийн судалгаа, аялал жуулчлалын шинжтэй арга хэмжээг аймгийн хэмжээнд жил тутам зохион байгуулж, цаашид уламжлал болгохыг зорьж ажиллана.
- 1.2 Ард иргэдийн эв нэгдэл, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх ажлыг нутгийн удирдлагын нэн тэргүүний ажил гэж үзнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАДРАН ГИЙХ МОНГОЛ ХҮН

- 2.1 Ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдлыг арилгах зорилгоор боловсролын хүртээмжийг сайжруулснаар аз жаргалтай Монгол хүнийг бий болгоно гэж үзнэ.
- 2.2 Боловсрол /Мэдлэг + Чадвар + Хүмүүжил + Ёс зүй + Хариуцлага + Θв соёл+.../-ын ойлголтыг зөв тодорхойлж, улс орноо хүчирхэг болгох зөв сэтгэлтэй иргэнийг бэлдэх бодлого баримтална.
- 2.3 Хүүхэд, өсвөр үеийнхнийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, амьдрах ухаанд сургахад чиглэгдсэн ном зохиол, бүтээл туурвилийг хөхүүлэн дэмжих бодлого баримтална.
- 2.4 Аймгийн хэмжээний сургууль бүрд төрөл бүрийн клуб, дугуйлан хичээллүүлж, хүүхэд бүр 2-оос дээш дугуйлан, клубт хамруулах бодлого баримтална.
- 2.5 Нэг хүүхдийн асуудлыг “Нэгдсэн сургалт”-ын хөтөлбөрт тусгах ажлыг санаачилж, хүүхэд бүрийн өөрийн оролцоонд тулгуурласан сургалтын орчныг бүрдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.
- 2.6 Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах, монгол хүний дундаж наслалтыг 75 насанд хүргэх эрүүл, аюулгүй, аз жаргалтай нийгмийг бүтээх бодлого баримтална.



- 2.7 Шинжлэх ухаанд сууриссан, шинжлэх ухааны бүтээлийг олон түмэнд таниулж, иргэн төвтэй үнэ цэнийг бий болгох бодлого баримтална.
- 2.8 Монгол анагаах ухааныг дэлхийн брэнд болгож, анагаах ухааны мэдлэг, судалгааны ажил, уламжлалт эмийг экспортлох хувийн хэвшлийг бодлогоор дэмжинэ.
- 2.9 Θндөр технологи, нано-технологи, инновацийн бүтээлийг бодлогоор дэмжинэ.
- 2.10 Аймгийн иргэд орон нутгатай ажиллаж хөдөлмөрлөх таатай орчныг бий болгохыг зорьж ажиллана.
- 2.11 Эмэгтэйчүүдийг хүчирхэг, эдийн засаг, санхүүгийн хараат бус, аз жаргалтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална.
- 2.12 Залуучуудыг гаднын өндөр хөгжилтэй улсад сурч, ажиллах нөхцөл боломжоор хангах зохион байгуулалтын ажлыг бодлогоор дэмжинэ.


ГУРАВДУГААР БҮЛЭГ АЧЛАЛТ ТӨР – ЗАСАГЛАЛ

- 3.1 Иргэдийн орон нутгаа хөгжүүлэх, ажил хэрэгч саналыг дэмжиж ажиллана.
- 3.2 Иргэн та асуудал дэвшүүлж, хүсэлтээ бидэнд гаргах юм бол бид тэр санал хүсэлтийг шийдвэрлэх хүртэл нэхэж ажилладаг хариуцлагатай улс төрийн хүчин байна.
- 3.3 Чадварлаг боловсон хүчин төрийн албан хаагчдын ажлын байрыг баталгаатай болгох бодлого баримтална.
- 3.4 Төрийн албыг цомхон, чадварлаг, хариуцлагатай, ёс зүйтэй ажилладаг болгон шинэчлэхийг зорьж, төрийн албан хаагч улс төрийн нөлөөллөөс болж ажлаас халдаг байдлыг бүрэн зогсоохыг зорьж ажиллана.
- 3.5 Төрийн албан хаагчдыг шилж сонгох, мэргэжил ур чадварыг нь дээшлүүлэх, идэвхжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НЭГЭН ЗҮЙЛ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 4.1 Гол мөрөн, ойн санг хамгаалах ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Мод тарих, бэлчээрийг нэхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх хөтөлбөрийг бодлогоор дэмжинэ.
- 4.2 Гамшигтай тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгон засаг захиргааны нэгж, бус нутгийн чадварыг сайжруулах бодлого баримтална.

ТАВДУГААР БҮЛЭГ
НЭГЭН ЗҮЙЛ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД



- 5.1 Төрөөс малчдын талаар баримталж буй бодлогын шинэчлэлийг санаачилж, малчдын нийгэм, эрүүл мэндийн баталгааг сайжруулах бодлого баримтална.
- 5.2 Аймгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааны үр ашгийг дээшлүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх бодлого баримтална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
НЭГЭН ЗҮЙЛ: БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 6.1 Дэлхий дахинь болон бус нутгийн улс тэр, эдийн засгийн хамтын ажиллагаанд харилцан ашигтай байх зарчмыг баримталж, идэвхтэй оролцохыг бодлогоор дэмжинэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
НЭГЭН ЗҮЙЛ: АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ҮНДЭС

- 7.1 Гадаад орнуудын хамтын ажиллагааг зохих шатанд дэмжиж ажиллахдаа үндэсний аюулгүй байдал, иргэдийн язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалах бодлого баримтална.

ҮНЭН ЯЛНА ҮР ҮЛДЭНЭ ...

